



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/304

Арвайхээр

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Арвайхээр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 12/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 7 нэгж талбарын газрын анхны үнэ, хэмжээ, байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулах бөгөөд дуудлага худалдааг 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсугай.

3. Дуудлага худалдаа явуулах зар мэдээг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг хүлээн авч дуудлага худалдааг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100656

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 4/304 дүгээр захирамжийн хавсралт



АРВАЙХЭЭР СУМЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ
БҮХИЙ ГАЗАРТ ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
АНХНЫ ҮНЭ, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ

№	Төлөвлөж буй газрын байршил	Төлөвлөлт ийн нэгж талбарын дугаар	Газар эзэмшүүлэх зориулалт	Эзэмшүүлэх газрын хэмжээ /м2/	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ (мян.төг)
1.	Онги 13 дугаар баг, шинэ Арвайхээр төв	2266835	5-8 давхар нийтийн орон сууц	4335	15606,0
2.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2252603	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	4360	10464,0
3.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2252604	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	7276	17462,4
4.	Онги 13 дугаар баг, шинэ Арвайхээр төв	2252606	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	1403	5050,3
5.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264134	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	10000	24000,0
6.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264135	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	10000	24000,0
7.	Арвайхээрийн 5 дугаар баг, Үйлдвэрлэлийн бүс	2264136	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, бусад газар	10000	24000,0
ДҮН				47374	120582.7